



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/544

Алтай хот

**Захирамж хэсэгчлэн хүчингүй болгох  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/279 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 2-т холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Намсрайн Батсайханы 060704012 нэгж талбарын дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд шинэчлэн бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/308 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийг хүчинтэйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР